



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 4/нн

Өлгий


Г Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг дэмжих тухай Г


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.4 заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 6 дугаар зүйлийн 6.2, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.12, 13.19 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шинжээчийн бүрэлдэхүүний 2025 оны 06 дугаар сарын 17-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах байгууллагыг хавсралтаар баталсугай.


2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Клиникийн бүтэц, үйл ажиллагааны стандарт шаардлагыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүссэн клиникт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах шинжээчийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАШЫРЖАН



Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 06 сарын 17 өдрийн А/у тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



НЭГ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:

1. “Ахсу” ХХК-ийн “Ахсу” рашаан сувилал “Улирлын чанартай”-г хасах.